

# Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2018

2018 оны тавдугаар сараас 2019 оны тавдугаар сар



**Бэлтгэсэн:**

Х.Наранжаргал  
Ц.Мөнхжин  
Л.Галбаатар  
Б.Пүрэвсүрэн  
Н.Зулзаяа

## ГАРЧИГ

<b>Өмнөтгөл</b> .....	3
<b>Нэг. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчил</b> .....	6
1.1. “Сэтгүүлчдийн аюулгүй байдалд нөлөөлж буй хүчин зүйлс” судалгааны үр дүн .....	6
1.2. 2018-2019 онд гарсан сэтгүүлчдийн мэргэжлийн эрхэд халдсан зөрчил.....	9
<b>Хоёр. Олон нийтийн мэдээлэл авах эрх, төрийн мэдээллийн хүртээмж</b> .....	12
2.1. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэх судалгааны үр дүн .....	12
<b>Гурав. Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн эсрэг иргэний болон эрүүгийн хэрэг</b> .....	14
3.1. Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтны холбогдсон хэрэг, маргааныг шийдвэрлэсэн байдал.....	15
<b>Дөрөв. Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин</b> .....	17
4.1. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгаа.....	18
4.2. Хэвлэлийн эрх чөлөө ба сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаа.....	20
4.3. Мэдээллийн эрх чөлөө ба хязгаарлалт.....	20
4.4. Сонгууль ба хэвлэл мэдээлэл.....	22
4.5. Нэр төр гутаахтай холбоотой зохицуулалт.....	23
4.6. Агуулгын хязгаарлалт.....	24
4.7. Бусад зохицуулалт.....	25

## ӨМНӨТГӨЛ

Жил бүрийн 5-р сарын 3-ны өдөр дэлхий даяар тэмдэглэдэг Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр” (ДХЭЧ)-т зориулан Монгол дахь Хэвлэлийн эрх чөлөөний тухай ээлжит тайлангаа та бүхэнд толилуулж байна. ЮНЕСКО-гоос 2019 оны ДХЭЧ-ний өдрийг “Хэвлэл мэдээлэл ардчиллын төлөө: Хуурамч мэдээллийн үе дэх сэтгүүл зүй ба сонгууль” сэдвийн дор тэмдэглэнэ.

ЮНЕСКО-гийн үзэл баримтлалын хүрээнд дэлхийн хэмжээнд болон дотооддоо нийтээрээ хэлэлцвэл зохих гурван дэд сэдвийг “Цахим эрин үе сонгуулийн мэдээлэл харилцаанд хэрхэн нөлөөлж байна вэ?”, “Хэвлэл мэдээллийн ардчилалд гүйцэтгэх үүргийг буруулах шинэ оролдлого: Мэргэжлийн сэтгүүл зүйд эргэлзээ төрүүлэх ба Интернэтийн хүртээмжид саад учруулах”, “Тогтвортой энх тайван, ардчилалд Хэвлэл мэдээллийн хувь нэмэр оруулах чадавх” хэмээн тодорхойлсон нь олзуурхуштай.

Өнгөрсөн УИХ, Ерөнхийлөгчийн сонгуулийн бохир сурталчилгаа бидний оюун санаанаас арчигдаагүй, 2020 оны УИХ, 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн урьдач нөхцөл бүрдэж эхэлж буй энэ цаг үед энэ жилийн ДХЭЧ-ний өдрийн сэдэв Монгол Улсын хувьд тун ч цагаа олжээ.

Чөлөөт, хараат бус, мэргэжлийн сэтгүүл зүй бол сонгогчдын мэдээлэлтэй, мэдлэгтэй сонголтын түшиц, сонгуулийн булхай, луйврын анч агаад хэвлэл мэдээлэл бол угтаа шударга ёс, шударга журмыг дээдлэгч ардчилсан нийгмийн хэмжүүр юм.

Хэвлэлийн хүрээлэнгийн судалгаагаар 2018 оны эцсийн байдлаар манай улсад 400 орчим хэвлэл мэдээллийн хэрэгсэлд 4462 хүн ажиллаж байна. Тэдний 49 хувь нь бүтээлч ажилтан буюу сэтгүүлч, сурвалжлагч байна.

2018 оныг Монголын сэтгүүл зүй олз омогтой, өгөөж арвинтай ч айдас түгшүүртэй үдэв. ЖДҮ-тэй холбоотой авлигын хэрэг олны дэмжлэг авч, өгөгдөлд суурилсан сэтгүүл зүйн ачаар иргэд тэдний эрх ашигт нийцсэн, урьд өмнө сонсоогүй олон мэдээлэлтэй танилцав.

Манай байгууллагын захиалгаар 2018 онд “GSP+ механизмаар дамжуулж хүний эрх, хөдөлмөрлөх эрхийг хөхиүлэн дэмжих нь” төслийн хүрээнд Монголын Хуульчдын холбоо, Хэвлэл мэдээллийн зөвлөл сэтгүүлчдийн аюулгүй байдал, эрх зүйн орчинд тус тус хийсэн мониторингийн урьдчилсан үр дүнг энэ тайланд тусгав. Тайлангийн эцсийн хувилбарыг бид тун удахгүй олны хүртээл болгоно.

ХМЗ-ийн мониторингийн дүнгээс харахад хамгийн багадаа хоёр сэтгүүлч тутмын нэгд мэдээлэл өгөхөөс татгалзсан, бичсэн нийтлэл, нэвтрүүлгээсээ болж ямар нэг дарамт, заналхийлэлд өртсөн, ажлын багаж хэрэгсэлд халдсан, нийтлэл, нэвтрүүлэг, ХМХ-ийг хориглосон, хориглохыг завдсан, нууц эх сурвалжаа илчлэхийг албадсан зэрэг мэргэжлийн эрхийн зөрчил тохиолдож байжээ. 2018 оны тавдугаар сарын байдлаар Монголын шүүхүүд хэвлэл мэдээллийн эсрэг нэр төр гутаахтай холбоотой иргэний 19 хэрэг шийдвэрлэсэн байна.

Монгол Улс НҮБ-ын Хүний эрхийн зөвлөмжийг хүлээн авч, 2017 онд сэтгүүлчдэд мэдээлэл түгээхэд, иргэдэд үзэл бодлоо илэрхийлэхэд нь хатуу цагдан хяналт болдог нэр төр гутаах, гүтгэлэг,

доромжлолтой холбоотой эрүүгийн хатуу зүйл заалтыг хэсэгчлэн халсан билээ. Харин Эрүүгийн хуулийн 14.8 дугаар зүйл буюу “Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах” гэмт хэрэгт /14.8.1/ сонгуульд оролцогч улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж, илт худал мэдээлэл тараасан бол 450-5400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 240-720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ гэсэн заалт үлдсэн юм.

Зөрчлийн тухай хуулийн “Гүтгэлэг” хэмээх заалт эдийн засгийн хүчтэй хэрэглүүр хэвээр байна. Уг хууль батлагдсан 2017 оны долоодугаар сарын нэгнээс 2018 оны 10 сарын байдлаар Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйлд заасан “Гүтгэх” гэсэн зөрчлөөр 374 зөрчил бүртгэж, 57 хүн, хоёр хуулийн этгээдийг 118 сая төгрөгөөр торгох шийтгэл ногдуулжээ.

2018 оны 12 дугаар сард Глоб Интернэшнл төв, МСНЭ, Хэвлэлийн хүрээлэн, Хэвлэл мэдээллийн зөвлөл, Өдөр тутмын сонины холбоо, Монголын телевизүүдийн холбоо зэрэг 15 байгууллага хамтран Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.21 дэх хэсгийг хасуулах саналыг Хууль зүй, дотоод хэргийн яамны ажлын хэсэгт илгээсэн билээ.

Улс төр, хууль тогтоогчдын хүрээнд гүтгэлэгтэй холбоотой нэр төр гутаах хэргийг эрүүгийн гэмт хэрэгт тооцож, Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулсан бөгөөд энэ нь хэвлэл мэдээллийнхний эсрэг эрх зүйн хүчтэй цензур болох аюул нүүрлэж болзошгүйд санаа зовж байна. Энэ нь Монгол Улсын хувьд, НҮБ-ын Хүний эрхийн 0000 зөвлөмжийг хүлээн авсан амлалтаасаа ухарсан хэрэг болно. Учир нь, олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх, Монгол Улсын нэгдэн орсон, соёрхон баталсан олон улсын гэрээ конвенц дотоодын хууль адил үйлчлэхээр тунхагласан Үндсэн Хуулийн 10-р зүйлтэй зөрчилдөж байгаа юм. Манай улс 1974 онд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактыг соёрхон баталснаар, үүний үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулсан 19-р зүйлийн хэм хэмжээг даган мөрдөх учиртай.

Энэ өдрүүдэд Монгол Улс Тогтвортой хөгжлийн зорилгуудын хэрэгжилтийн талаарх Үндэсний сайн дурын илтгэлээ анх удаа 2019 оны 7-р сард болох НҮБ-ын Улс төрийн өндөр түвшний чуулга уулзалтад тавихаар бэлтгэж байна. ТХЗ-ын 16.10 дахь дэд зорилтод “Үндэсний хууль тогтоомж болон олон улсын гэрээ хэлэлцээрт нийцүүлэн олон нийтийг мэдээлэл олж авах боломжоор хангах, үндсэн эрх чөлөөг хамгаалах” гэж заасан билээ. 2011 онд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг баталсан. Энэ хуулийг дэлхийн улс орнуудын мэдээлэл авах эрхийн хуулийн үнэлгээгээр жагсаахад 123 орноос 72-рт жагсаж байна.

2019 оны 3 дугаар сард Глоб Интернэшнл төв “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг үнэлэх судалгаа хийсэн. Энэ судалгааны үр дүнд төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдал 36 хувь, хуулийн хэрэгжилтийг хангах байдал 26 хувь, иргэд, олон нийт мэдээлэл хүсэхэд хариу өгөх байдал 59 хувь гэж гарчээ.

Харин ХМЗ-ийн судалгаагаар “Төрийн албан тушаалтан мэдээлэл өгөхөөс татгалзаж байсан тохиолдол 10 сэтгүүлч тутмын 7-д дор хаяж нэг удаа тохиолдож байсан” гэжээ.

Монгол Улс 2018 оны 5-р сард Хүний эрхийн ТББ-ын Форумаас НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд Монгол улсын хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт, хэлэлцүүлэг (UPR)-ийн тухай үндэсний тайлангийн хэрэгжилтийн дунд шатны тайлангаа илгээсэн. 2016 оны 4-р сарын 11-ний өдөр Засгийн газрын “Ерөнхий төлөвлөгөө батлах тухай” 204 тоот тогтоол батлагдсан. Үйл ажиллагааны төлөвлөгөөнд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний талаар өгсөн 8 улсын зөвлөмжийг хэрэгжүүлэх 11 үйл ажиллагаа тусгаснаас ес нь огт хэрэгжүүлж эхлээгүй байна.

2020 оны тавдугаар сард НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл Монгол Улсын хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт, хэлэлцүүлэг (UPR)-ийн дараагийн ээлжит үндэсний тайланг хэлэлцэнэ. Тэр үед Монголын Засгийн газар ХЭЗ-ийн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд дорвитой амжилтад хүрсэн байна гэдэгт найдаж байна.

Улс төрчид үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөөг хатуу хязгаарлах, нийгмийн сүлжээг хаах, хязгаарлах тухай үе үе мэдэгдэл хийж байна. News.mn мэдээний сайт 2019 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэх үеэр нийгмийн сүлжээнд нэрээ нуусан хаягаас бусдын нэрээр орохыг хориглох, регистрийн дугаараар нь бүртгэх тухай хэлэлцсэн тухай мэдээлсэн нь олны анхаарлыг татаж байна.

2018 онд “Хил хязгааргүй сурвалжлагчид” (RSF) олон улсын байгууллагын Хэвлэлийн эрх чөлөөний индексээр Монгол Улс дэлхийн 180 орноос 70 дугаар байранд жагсаж, хэвлэлийн эрх чөлөөний “мэдэгдэхүйц асуудал”-тай орны тоонд багтсан хэвээр байна.

Энэ тайлан та бүхэнд Монголын хэвлэл мэдээллийн эрх чөлөөний ерөнхий дүр зургийг харуулна гэдэгт найдаж байна.

**Х.Наранжаргал**  
**Глоб Интернэшнл төвийн тэргүүн**

## НЭГ. ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ЗӨРЧИЛ

### 1.1. “СЭТГҮҮЛЧДИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС” СУДАЛГААНЫ ҮР ДҮН

2018-2019 онд Глоб Интернэшнл төвийн захиалгаар Монголын Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс хийсэн “Сэтгүүлчийн аюулгүй байдлын түвшин тодорхойлох” судалгаанд өдөр тутмын мэдээ мэдээлэл, эрэн сурвалжлах, нийгэм эдийн засгийн чиглэлээр бичдэг 300 сэтгүүлчийг хамруулсан. Судалгааны дүнгээс харвал мэдээлэл өгөхөөс татгалзсан, бичсэн нийтлэл, нэвтрүүлгээс ямар нэг дарамт, заналхийлэлд өртсөн, ажлын багаж хэрэгсэлд халдсан, нийтлэл, нэвтрүүлэг, ХМХ-ийг хориглосон, хориглохыг завдсан, нууц эх сурвалжаа илчлэхийг албадсан зэрэг зөрчлүүд хамгийн багадаа хоёр сэтгүүлч тутмын нэгд тохиолдож байжээ.

#### Сэтгүүлчийн аюулгүй байдлын шалгуур үзүүлэлт



Эдгээр зөрчил нь телевиз, цахим сайт, сонинд ажилладаг 35 хүртэлх насны залуу сэтгүүлчдэд илүүтэй тохиолддог байна.

- Сэтгүүлчдэд мэдээлэл өгөхөөс татгалзаж байна



Төрийн албан тушаалтан “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийн дагуу мэдээлэл өгөхөөс татгалзаж байсан тохиолдол 10 сэтгүүлч тутмын 7-д дор хаяж нэг удаа тохиолдож байсан.

Төрийн байгууллага нь нууцад хамаарах мэдээллийн жагсаалтаа дотоод зохион байгуулалтын хүрээнд гаргадаг ба хэт ерөнхий хүрээнд тодорхойлсон байдаг. Энэ нь тухайн байгууллага өөрийн цензурээр мэдээллийг нууц гэж томъёолж, мэдээлэл олж авах, түгээхэд саад хийх нөхцөлийг бүрдүүлж байна.

- **Заналхийлэл улам гаарч байна**



Нийт сэтгүүлчийн 67 хувь нь бичсэн нийтлэл, олон нийтэд түгээсэн мэдээллээсээ болоод ямар нэгэн дарамт, сүрдүүлэгт дор хаяж нэг удаа өртөж байсан.

Сэтгүүлч бичсэн нийтлэл, олон нийтэд түгээсэн мэдээллээсээ болж утсаар заналхийлэлд өртөх, сэтгүүлч болон редакцийн бусад гишүүдийг айлгаж дарамтлах, олны өмнө доромжлох, эрх мэдэл бүхий өндөр албан тушаалтан дарамтлах зэрэг нь хамгийн түгээмэл ба нэг сэтгүүлчдунджаар 3-4 удаа энэ төрлийн заналхийлэлд өртөж байжээ.

- **Ажлын багаж хэрэгсэлд халдаж байна**



Судалгаанд хамрагдсан нийт сэтгүүлчийн 58 хувьд ажлын багаж хэрэгсэлд халдах тохиолдол дор хаяж нэг удаа тохиолдож байсан.

Сэтгүүлчийн бэлтгэсэн мэдээ, мэдээллийг цааш задруулахгүй байх зорилгоор камерыг булаах, эвдлэх, санах картан дахь мэдээллийг устгах зэрэг ажлын багаж хэрэгсэлд халдах явдал гардаг.

- **Редакцийн цензурхүчтэй хэвээр байна**



Нийтлэл, нэвтрүүлэг, ХМХ-ийг хориглосон, эсвэл хориглохыг завдсан, редакцийн цензур гэх мэт бүх төрлийн цензур нийт сэтгүүлчийн 52 хувьд буюу хоёр сэтгүүлч тутмын нэгд тохиолдож байсан.

Нийтлэл нэвтрүүлгийг нийтлэгдэх, нэвтрүүлэхээс өмнө хориглож буй зөрчил нь зөвхөн нэр дурдагдсан байгууллага, албан тушаалтан бус хэвлэл мэдээллийн байгууллагын эзэн, эрх мэдэл бүхий албан тушаалтан, мэргэжил нэгт сэтгүүлчдийн нөлөөлөл, хаалтын гэрээ зэргээр илэрч байна.

- **Нууц эх сурвалжаа илчлэхийг албадаж байна**



Нууц эх сурвалжаа илчлэхийг албадсан тохиолдол нийт сэтгүүлчийн 51 хувь буюу хоёр сэтгүүлч тутмын нэгд тохиолдож байжээ.

Сэтгүүлчийн бичсэн мэдээ, нийтлэл гарсны дараа нэр дурдагдсан байгууллага болон эрх мэдэл бүхий албан тушаалтан ямар эх сурвалжаас мэдээлэл авсан тухай асуудаг. Мөн сэтгүүлчийн эсрэг шүүхэд гомдол гаргаж, тухайн мэдээллийн баримтаа нотлохыг шаарддаг нь нууц эх сурвалжаа илчлэхээс өөр аргагүй байдалд оруулж байна.

- **Сэтгүүлчид шүүх, хүчний байгууллагын дарамтад өртөж байна**



Судалгаанд оролцогчдоос “Таны бэлтгэсэн нийтлэл, нэвтрүүлэгтэй холбогдуулан шүүх, цагдаагийн байгууллагад хэрэг үүсгээдэж байсан уу? гэж асуухад 36 хувь нь буюу гурван сэтгүүлч тутмын нэг нь *тийм* гэж хариулсан.

Төрийн байгууллага, төрийн байгууллагын эрх мэдэл бүхий албан тушаалтан, улс төрчидсэтгүүлчдийн эсрэг шүүхэд гомдол гаргах тохиолдол хамгийн их байна. Зөрчлийн тухай хууль батлагдаж, дагаж мөрдөгдөж эхэлснээс хойш гомдол гаргагсдын тоо өссөөр байна.



## **1.2. ГЛОБ ИНТЕРНЭШНЛ ТӨВ 2018 - 2019 ОНД СЭТГҮҮЛЧДИЙН МЭРГЭЖЛИЙН ЭРХЭД ХАЛДСАН ДАРААХ ЗӨРЧЛИЙГ ОНЦОЛЖ БАЙНА**

### **КЭЙС 1**

#### **Сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагаанд саад хийв**

2018 оны 12-р сарын 12-ны өдөр сурвалжлага бэлтгэхээр “Шангри-Ла” зочид буудалд очсон “Засгийн газрын мэдээ” сонины сэтгүүлч Э.Батцэцэг, фото сэтгүүлч С.Батсайхан нарын сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаанд буудлын хамгаалалтын ажилтнууд халдлаа.

АНУ-ын иргэн, зэвсэгт хүчний хошууч М.К.Стюарт гэх эр Улаанбаатар дахь “Шангри-Ла” зочид буудлын өрөөнд өөрийгөө боомилсон байдалтай нас барсан. Тэрбээр Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Төрийн департаментын хамтын ажиллагааны хүрээнд ажлын шугамаар манай улсад ажлаар иржээ. Хэргийг Сүхбаатар дүүргийн Цагдаагийн нэгдүгээр хэлтэст шалгаж буй. Засгийн газрын мэдээ сонины фото сэтгүүлч С.Батсайхан 4 цаг хүлээсний эцэст талийгаачийн цогцсыг шүүх эмнэлгийн машин ирж авах үед гэрэл зургаар үйл явдлыг баримтжуулсан байна. Гэтэл хамгаалалтын албаныхан тухайн зурагчныг хөөж баривчлаад, зургийн аппаратыг нь булааж, гарыг нь мушгиад буудал руу чирч оруулжээ. Түүнчлэн редакцийн даалгавраар мэдээлэл бэлтгэж явсан сэтгүүлчийн биед нэгжлэг хийж, утсыг нь шалгаж, дотроос нь зургийг устгасан байна.

### **КЭЙС 2**

#### **УИХ-ын гишүүн Х.Нямбаатарын гомдлоор сэтгүүлчийг торгов**

“iNews.mn” сайтын сэтгүүлч Ц.Булганзаяаг УИХ-ын гишүүн Х.Нямбаатарыг гүтгэсэн гэх хэргээр шүүхээс хоёр сая төгрөгийн торгууль ногдууллаа. 2018 оны 12-р сарын 26-нд Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээс Х.Нямбаатар гишүүнийг хохирогчоор тогтоож, цагдаагийн байгууллагаас Булганзаяа сэтгүүлчид оногдуулсан торгуулийн ялыг хэвээр үлдээжээ. Тэрбээр 2018 оны 6-р сарын 27-нд iNews.mn сайтад “У.Хүрэлсүхийн Засгийн газар унах нүхээ өөрөө малтав” гэсэн гарчигтай нийтлэлдээ УИХ-ын гишүүн Х.Нямбаатарыг Ц.Нямдоржийн “утсан хүүхэлдэй” гэж нэрлэсэн нь ийнхүү шийтгэл оногдуулах шалтгаан болжээ. Тухайн нийтлэлд дурдагдсан үйл, баримтыг няцаах ямар ч оролдлого хийгээгүй, эсрэг баримт нотолгоо гаргаагүй бөгөөд шүүхийн байгууллага ч үгүйсгээгүй бөгөөд зөвхөн “утсан хүүхэлдэй” гэдэг үгэнд үндэслэж “Х.Нямбаатарыг гүтгэсэн” гэдэг дүгнэлт гаргасан байна.

Эхлээд харьяаллын дагуу Чингэлтэй дүүргийн цагдаагийн хэлтэс зөрчлийн хэрэг нээсэн. Гэтэл 2018 оны 8-р сард Нийслэлийн прокурорын тушаалаар төрийн өндөр албан тушаалтнуудтай холбоотой зөрчлийн хэргийг ЦЕГ-ын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах хэлтэст шилжүүлж, нэг дор төвлөрүүлэн шалгадаг болжээ. Ингээд тус хэлтсийн мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Г.Цэрэнжаргалын шийдвэрээр томилсон шинжээч МУБИС-ийн НХУС-ийн Монгол хэлний тэнхимийн эрхлэгч, доктор профессор Ш.Баттөгс “Утсан хүүхэлдэй, хуулийн ченж гэдэг

үг нь хүнийг гүтгэсэн, доромжилсон утгыг шууд илэрхийлэхгүй. Тухайн үйл, баримтанд тулгуурласан, хувь хүний үзэл бодол, үнэлэмжийн асуудал байна” гэсэн дүгнэлт гаргасан байна. Гэвч шинжээчийн дүгнэлтийг харгалзалгүйгээр сэтгүүлч Булганзаяад Зөрчлийн тухай хуулийн 6.21 дэх зүйл заалтаар 2 сая төгрөгийн торгууль оногдууллаа.

### **КЭЙС 3**

#### **Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд эдийн засгийн давхар цензур ногдуулав**

УИХ-ын гишүүн Б.Ундармаа 2018 оны 6-р сарын 07-нд “Өнөөдөр” сониныг шүүхэд өгсөн байна. Ингэхдээ гүтгэлгийн шинжтэй нийтлэлүүд гаргасан учраас нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд нь халдсан гэж үзэн 100 сая төгрөг нэхэмжилжээ. Тэрбээр “Өнөөдөр” сонинд гарсан “УИХ-ын гишүүн Б.Ундармаа хувийн ашиг сонирхол, хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-тээ бүртгүүлээгүй компани нэхэмжилжээ”, “УИХ-ын гишүүн Б.Ундармаа хуурамч баримтаар гэрчилгээ гаргуулж авсан гэв” гэх нийтлэлүүдийг 42, цахим хуудсанд хэвлэгдсэнийг 15, бусад сайтад дамжин хуулсныг 25, өмгөөлөгчийн хөлсөө найман сая гэж үнэлэн нийт 100 сая төгрөг нэхэмжилжээ. “Өнөөдөр” сонин өөрсдийн бэлтгэн нийтэлсэн материалуудаа баримтаар баталгаажсан гэж үзэж буйгаа мэдэгдээд байгаа юм. Өнгөрсөн хугацаанд “Алтайн хүдэр” ХХК “Өнөөдөр” сониноос 9 тэрбум төгрөг нэхэмжилсэн ч өргөдлөө буцаан татаж авсан түүхтэй бол “Уулс Заамар” компанийн 100 сая төгрөг нэхэмжилсэн хэрэг нь одоо хүртэл шүүхээр шалгагдсан хэвээр байгаа аж.

### **КЭЙС 4**

#### **Нотлох баримтуудыг үл ойшоон зөрчлийн тухай хуулиар сэтгүүлчийг торголоо**

Сэтгүүлч С.Будрагчаа нь 2018 оны нэг сараас дөрвөн сарын хооронд “Нийслэлийн архивын газрын дарга С.Гавааг АТГ шалгаж байна”, “Нийслэлийн цахим архивын программыг төрийн байгууллагуудад дамлан худалджээ”, “Архивын баримтуудыг хадам эзжийнхээ СӨХ-д 5.000.000 төгрөгөөр хадгалуулжээ”. “Нийслэлийн архивын газрын дарга С.Гаваа өөртөө 2.000.000 төгрөгийн зөвлөгөө өгчээ” гэсэн гарчиг бүхий дөрвөн удаагийн цуврал нийтлэл бичсэний улмаас бусдын нэр төр, алдар хүндэд халдаж гүтгэсэн гэх хэрэгт шийтгэл оногдуулж зөрчлийн тухай хуулиар 2.000.000 сая төгрөгөөр торгохоор болсон. Тус шийтгэлийг эс зөвшөөрч Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд хандсан бөгөөд 2018 оны 10 дугаар сарын 12-нд болсон шүүх хурлаар шийтгэврийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн. Ингэхдээ шүүх нь хэрэгт авагдсан нотлох баримтыг үнэлээгүй, хэт нэг талыг барьж шийдвэр гаргасан. Иймд анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасан бөгөөд 2019.04.30-ны өдрийн шүүх хурлаар зөрчлийн үйл баримтууд тодорхойгүй, шүүхээс хэрэгт хууль зүйн үндэслэл бүхий дүгнэлт хийгдээгүй байна гэсэн үндэслэлээр анхан шатны шүүхэд хэргийг буцаахаар болсон.

## **КЭЙС 5**

### **Сэтгүүлчийн бие махбодид халдлаа**

Бүгд Найрамдах Турк Улсын иргэн Вейсел Акчайг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвшөөрөлтэй оршин сууж байхад нь хулгайлахыг завдсан хэрэг гарсан бөгөөд монголын хэвлэл мэдээллийн хэрэгслүүд үүнийг мэдээлж байлаа.Тухайн үеийг сурвалжилж байсан сэтгүүлчдийг ЦЕГ-ын Гэрч, хохирогчдыг хамгаалах хэлтсийн албан хаагчид цохиж, түлхэж, үсдэж зарим сэтгүүлчдийг авч шидсэн хэрэг гарсан. Eagle телевизийн сэтгүүлч Б.Батцэцэгийг цагдаагийн албан хаагч шанаадаж байгаа бичлэг камерт үлдсэн байдаг. Редакцаас нь цагдаагийн байгууллагад гомдол гаргасан боловч нэр бүхий албан хаагчийг ажлаа хийж байсан хэмээн үзэж хариуцлага тооцолгүй орхисон.

## ХОЁР. ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХ, ТӨРИЙН МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖ

### 2.1. “МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ” ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Монгол Улсын Үндсэн хуулиар ард иргэдийнхээ үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө, мэдээлэл олж авах эрх, хэвлэн нийтлэх эрхийг баталгаажуулсан. 2011 онд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл олж авах эрхийн тухай хуулийг баталсан. Энэ хуулийг дэлхийн улс орнуудын мэдээлэл авах эрхийн хуулийн үнэлгээгээр жагсаахад манай улс 123 орноос 72-рт жагсаж байна. (<https://www.rti-rating.org/country-data/>).


Глоб Интернэшнл төв 2019 оны гуравдугаар сард Мэдээллийн Эрх Чөлөөний Өмгөөлөгчдийн Сүлжээ (FOIANet Network)- ээс бэлтгэсэн аргачлалын дагуу Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэх судалгааг хийсэн бөгөөд энэ судалгаанд санамсаргүй түүврийн аргаар төрийн найман байгууллагыг хамруулсан.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл олж авах эрхийн тухай хууль нь төрийн байгууллагуудын ил тод байдал, сайн засаглалыг баталгаажуулахын тулд өөрсдийн үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авалтын үйл ажиллагааны талаарх мэдээллээ олон нийтэд мэдээллэхийг үүрэг болгодог. Иргэн, хуулийн этгээд аливаа мэдээллийг хүсэх эрхтэй. Түүнчлэн иргэд, олон нийт төрийн байгууллагуудаас мэдээлэл хүсэх, хуулийн дагуу мэдээллийг авах эрхтэй бөгөөд энэ нь төрийн байгууллагуудын мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх үндэс болно.

Төрийн байгууллагууд иргэдийн хүсэлтийн дагуу ажлын долоо хоногийн дотор хариу өгөх үүрэгтэй бөгөөд хэрэв шаардлагатай гэж үзвэл заасан хугацааг нэг удаа долоо хоногоор сунгаж болно. Хэрэв олон нийт тухайн мэдээллийг цахим хуудас болон бусад хэлбэрээр авах боломжтой бол шууд авч болно. <https://www.legalinfo.mn/law/details/374>

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтэд тулгарч буй саад бэрхшээлүүдийн нэг нь Засгийн газар тухайн хуулийг өргөн хүрээнд сурталчилдаггүй, үүнээс үүдэн энэ хуулийн хүрээ, ойлголт төрийн байгууллагуудад янз бүр байна. (Монгол дахь хэвлэл мэдээллийн хөгжлийг үнэлэх, үнэлгээ 2016, Юнеско)

#### ▪ Судалгааны үр дүн



Агуулга	Үнэлгээ
Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдал	35.4%
Төрийн байгууллага хуулийн хэрэгжилтийг хангасан байдал	25.9%
Мэдээлэл авахыг хүсэлтэд хариу өгөх байдал	58.2%

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн хуулийн хэрэгжилтийг хариуцдаг тусгай хороо Монгол улсад байхгүй. Төрийн байгууллагын мэдээллийн ажилтнууд энэ хуулийн талаар хангалттай мэдлэггүйгээс гадна энэ чиглэлээр албан ёсны сургалтад хамрагдаагүй. Тиймээс байгууллагын нууц болон мэдээллийн нууцлалын тухай хэвшмэл ойлголттой байна.

## ГУРАВ. СЭТГҮҮЛЧ, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭСРЭГ ИРГЭНИЙ БОЛОН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ

Глоб Интернэшнл төв нь улсын хэмжээнд 2017 онд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан иргэний хэрэг, маргаан, бусдыг гүтгэсэн, доромжилсон эрүүгийн хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдлыг судлан, Иргэний болон Эрүүгийн хуулийн зохих зүйл заалтыг улс төрчид, төрийн өндөр албан тушаалтан, төрийн албан хаагч, төрийн байгууллага хэрхэн ашиглаж буйд судалгаа хийв. Хэдийгээр хүчингүй болсон ч Эрүүгийн хуулийн 111, 112 дугаар заалт болох Гүтгэх, Доромжлох зүйл ангийн үйлчлэх хугацааг шинэ хууль хэрэгжиж эхэлсэн 2017 оны 7 дугаар сарын 1 хүртэлх хугацаагаар зааглаж үзсэн.

Монгол Улсын Иргэний хуулийн 21, 27, 497, 511 дүгээр зүйлүүдэд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах, учирсан гэм хорын хохирлыг арилгах, Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйлд “Хүний нэр төр, алдар хүнд хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан.

2017 оны нэг сараас 2019 оны 04 дүгээр сар хүртэлх хугацаанд Монгол Улсын хэмжээнд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндтэй холбогдох иргэний 69 хэрэгшийдвэрлэснээс 19 нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой байна. Эдгээрээс шүүхээр шийдвэрлэсэн 12 хэрэгтэй танилцах боломжтой байв.

Нэхэмжлэл гаргагчдын 33% нь төрийн өндөр албан тушаалтан, төрийн албан хаагч, төрийн байгууллага байна. Шүүхийн шийдвэрийн төрлийг авч үзвэл, нэр төр, ажил хэргийн нэр хүнд гутаагдсаныг сэргээж, мэдээг тараасан хэлбэр, хэрэгслээр няцаалт хийж, залруулга гаргахыг даалгасан 7, талуудын эвлэрлийг баталсан 4, нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон 1 шийдвэр байна.

2017 онд эдийн бус гэм хорын хохиролд олны танил улс төрч хэвлэл мэдээллийн хэрэгслээс 75 сая төгрөг нэхэмжилсэн боловч анхан шатны шүүхээс түүний нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгожээ. Нэхэмжилсэн мөнгөн дүнгийн дээд хэмжээ 104,7 сая төгрөг байгаа нь 2016 онтой харьцуулахад 50 гаруй сая төгрөгөөр буурчээ. Нэхэмжлэл гаргагчид дунджаар 20 сая төгрөг нэхэмжилжээ. Шүүхийн шийдвэрээр хариуцагчаас гаргуулахаар шийдвэрлэсэн мөнгөн дүнгийн дээд хэмжээ 2 сая төгрөг байсан бөгөөд энэ нь өнгөрсөн оныхтой адил дүнтэй байна.

Анхан шатны шүүхийн шийдвэрээр хэргийн 6 буюу 50% нь нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон бол гэм буруутай гэж үзсэн 3 хэрэг байна. Нэхэмжлэгч, хариуцагч хоорондоо эвлэрсэн 3 хэрэг байна.

1999-2017 онд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, гүтгэлэг, доромжлолтой холбоотой шүүхээр шийдвэрлэгдсэн нийт иргэний болон эрүүгийн **848** хэргийн **426** буюу **50.2%** нь сэтгүүлч,

хэвлэл мэдээллийн хэрэгсэлд холбогдох хэрэг байна. (Судалгааг [shuukh.mn](http://shuukh.mn) цахим хуудасны мэдээлэлд үндэслэн хийв.)

### 1999-2018 оны хэргийн харьцуулсан үзүүлэлт

Он	Иргэний хэрэг		Эрүүгийн хэрэг	
	Нийт хэрэг	ХМХ-д хамаарах	Нийт хэрэг	ХМХ-д хамаарах
1999	30	-	3	-
2000	39	-	-	-
2001	31	11	4	-
2002	44	37	2	2
2003	28	18	1	1
2004	40	40	1	1
2005	29	25	1	1
2006	36	31	3	3
2007	33	33	-	-
2008	39	25	5	5
2009	44	17	1	-
2010	67	37	2	-
2011	43	23	7	3
2012	43	20	8	4
2013	37	17	9	3
2014	45	20	12	9
2015	37	10	14	5
2016	47	12	9	1
2017	49	12	5	0
2018	69	19	0	0
<b>Нийт</b>	<b>761</b>	<b>388</b>	<b>87</b>	<b>38</b>

**Тайлбар:** 2017,2018 онд ХМХ-д хамаарах эрүүгийн хэргийн бүртгэл байхгүй байгаа нь 2017 оны 07 дугаар сарын 1-нээс дагаж мөрдсөн Эрүүгийн хуулиар Гүтгэх, Доромжлох зүйл ангийг гэмт хэрэгт тооцохгүй болсонтой холбоотой.

### 3.1. СЭТГҮҮЛЧ, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН АЖИЛТНЫ ХОЛБОГДСОН ХЭРЭГ, МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

#### А. Эрүүгийн хэрэг

- 2015-2017 оны байдлаар нийт 28 сэтгүүлч Эрүүгийн хуульд заасан тодорхой төрлийн гэмт хэрэгт сэжигтнээр татагдсан байх бөгөөд гэмт хэргийн улмаас нийт 70 сэтгүүлч хохирсон байна.

## **Б. Зөрчлийн хэрэг**

- 2017 он, 2018 оны эхний 3 сарын байдлаар, Зөрчлийн тухай хуульд заасан тодорхой төрлийн зөрчилд 46 сэтгүүлч буруутгагдсан байна.
- 2017, 2018 оны 2 дугаар сарын байдлаар, нийт 11 сэтгүүлчид холбогдох нийт 12 тохиолдлын “гүтгэх” зөрчил үйлдсэн буруутайд тооцогдож, торгуулсан байна.
- 2017 онд шүүхээс гүтгэх зөрчлийн талаарх эрх бүхий албан тушаалтны нийт 6 шийдвэрийг /шийтгэвэр/ хянаснаас, 4 шийдвэрийг хэвээр үлдээж, 2 шийтгэврийг хүчингүй болгож холбогдогчийг шийтгэлээс чөлөөлсөн байна.
- 2018 онд шүүхээс гүтгэх зөрчлийн талаарх эрх бүхий албан тушаалтны нийт 32 шийдвэрийг /шийтгэвэр/ хянаснаас, 19 шийдвэрийг хэвээр үлдээж, 13 шийтгэврийг хүчингүй болгосон байна.

## **В. Иргэний хэрэг**

- 2017.01-2019.04 сарыг хамрах хугацаанд шүүхийн шийдвэрийн цахим санд эдийн бус гэм хорыг арилгах /нэр, төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан/-тай холбоотой шүүхийн нийт 69 шийдвэр байна. Үүнээс сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэл хариуцагчаар татагдсан 19 хэрэг байна. Шүүхийн шийдвэртэй танилцах боломжтой 12 хэргээс нэхэмжлэгчдийн 4 буюу 33% нь улс төрч, төрийн удирдах албан тушаалтан, захиргааны байгууллагын албан хаагч байна. Нийт 12 хэргийн 6-д нь гэм хорын хохирол нэхэмжилсэн байх бөгөөд нийт 104.7 сая төгрөг, дунджаар 20сая төгрөгийг нэхэмжилсэн байна. Шүүхийн шийдвэрийн төрлийг авч үзвэл, нэр төр, ажил хэргийн нэр хүнд гутаагдсаныг сэргээж, мэдээг тараасан хэлбэр, хэрэгслээр няцаалт хийж, залруулга гаргахыг даалгасан 7, талуудын эвлэрлийг баталсан 4, нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон 1 шийдвэр байна. Мөн шүүхээс 75 сая төгрөгийн үнийн дүн бүхий гэм хорын хохирлыг хэрэгсэхгүй болгожээ. Харин үлдэх гэм хорын хохирлын хувьд талууд эвлэрсэн байна.

Эндээс үзэхэд, шүүхээс дараах үндэслэлийг баримталж байна. Үүнд: **1)** Хүний нэр төр, алдар хүнд, эрх хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх үүрэгтэй /Үндсэн хууль, 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэг/. **2)** Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ /Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3.1 дэх хэсэг/. **3)** Иргэний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотлох үүрэгтэй. Тодруулбал, нийтлэлдээ дурдсан мэдээллийн үнэн зөвийг, бодит байдалд нийцсэнийг баримтаар нотлох шаардлагатай./Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, 511 дүгээр зүйлийн 511.1 дэх хэсэг/ **4)** Өөр хэвлэлийн мэдээг өөрчлөлтгүйгээр нийтлэх тохиолдолд мэдээлэл нь үнэнд нийцсэн эсэхийг баталгаажуулж, эх сурвалжийн баталгаатай эсэхийг нягтлах үүрэгтэй.

- 2018 оны 5 дугаар сарын 03-ны өдрөөс 10 дугаар сарын 01-ний хооронд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасантай холбоотой нийт 5 хэргийг шүүх хянан шийдвэрлэжээ. Эндээс харахад, нэхэмжлэгч буюу хохирогчийн зүгээс нэр төр гутаах, доромжлох, гүтгэхтэй холбоотой хохирлын хэмжээг харилцан адилгүй тодорхойлж байх бөгөөд шүүхээс тэрхүү хохирлын хэмжээ баримтаар нотлогдож буй эсэхийг шууд харгалзаж байна.



## ДӨРӨВ. ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

“GSP+ механизмаар дамжуулж хүний эрх, хөдөлмөрлөх эрхийг хөхиүлэн дэмжих нь” төслийн хүрээнд Глоб Интернэшнл төвийн захиалгаар Монголын Хуульчдын холбоо “Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн дүн шинжилгээ” сэдвийн хүрээнд судалгааны ажлыг хийж гүйцэтгэв. Энэ хүрээнд Монголын Хуульчдын холбооны судалгааны багаас 2017, 2018 оны байдлаарх статистикийн мэдээлэл, эрх зүйн зохицуулалтад зохих дүн шинжилгээ хийх замаар Монгол Улс дахь үзэл бодолтой байх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийн талаарх өнөөгийн эрх зүйн орчныг нэгтгэн дүгнэв.

### Эрх зүйн зохицуулалт:

- Монгол Улс үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх эрх чөлөөтэй холбоотой хүний эрхийн олон улсын нийт 17 гэрээ, конвенц, тэдгээрийн нэмэлт протоколд нэгдэн орж, зохих үүрэг хүлээсэн байна. Үүнээс голлох буюу үндсэн олон улсын гэрээ нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт юм.
- Монгол Улсад үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх эрхийг баталгаажуулсан голлох хууль нь Монгол Улсын Үндсэн хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Эрүүгийн хууль (1.4 дүгээр зүйлийн 4-т зааснаар “Хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй”, 14.2 дугаар зүйлд “Мэдээлэл хайх, хүлээн авахад саад учруулах”, 14.3 дугаар зүйлд “Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах” нь тус тус гэмт хэрэг байхаар зохицуулсан.) юм. Монгол Улсын Үндсэн хуулийн 16.16 болон Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 1 болон 2 зүйл нь хүний үзэл бодлоо ирэлхийлэх эрхийг хамгаалсан байна. Харин Эрүүгийн Хуулийн 14.2 болон 14.3 болон Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмын 2,3 дугаар зүйлүүд нь үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээх авах эрх нь нээлттэй хэдий ч нууцын зэрэгтэй зүйлсийг хадгалах үүрэгтэй гэдгийг харуулж байна.
- 2017-2018 онд батлагдсан дотоодын хууль тогтоомжоос мэдээлэх, мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулиудыг түүвэрлэхэд, 2017 онд нийт 68 хууль батлагдснаас 18 хуульд, 2018 онд 35 хууль батлагдсанаас нийт 6 хуульд мэдээлэх, мэдээлэл авах эрхийн талаар тусгасан байна.
- Нэр төр гутаах, доромжлох үйлдэл болон гүтгэлгийг эрүүгийн хэрэгт тооцохгүйгээр, Иргэний хуульд зааснаар иргэний хэргээр шийдвэрлэж болохоор зохицуулсан. Гэвч, “Гүтгэх” хэрэг нь эрүүгийн хэрэг биш Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил бөгөөд, Эрүүгийн хуульд гүтгэлэгтэй төстэй зохицуулалтууд үлдсэн байна. Тодруулбал, Эрүүгийн хуулийн 14.8 дугаар зүйл буюу “Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах” гэмт хэрэгт /14.8.1/ сонгуульд оролцогч улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж, илт худал мэдээлэл тараасан бол 450-5400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 240-720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ гэж заасан. Илт хууль бус мэдээлэл тараах гэдэг нь гүтгэхтэй төстэй байна.

- Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13, 16, 17 дахь хэсэг, Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 34 дүгээр зүйл /Мэдээлэл олж авах, мэдээллийн эх сурвалжийг нууцлах/, Эрүүгийн хуулийн 14.3 дугаар зүйлд /Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах/ эх сурвалж хамгаалах болон хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалсан дотоодын хуулийн зохицуулалт болж байна.

#### **Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангах, зөрчигдөхөөс сэргийлэх механизм:**

- 2011 оны 6 дугаар сарын 16-ны өдөр батлагдсан Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 17.1-т “Иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл авах эрхийг зөрчсөн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдлийн талаар дээд шатны байгууллага, албан тушаалтан, Хүний эрхийн Үндэсний Комисс, эсхүл шүүхэд гомдол гаргаж болно” гэж заасан нь тус хуулийн хэрэгжилтийг хянах механизм болж байна. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын Ажлын албанаас Монголын Хуульчдын холбоонд 2018 оны 10 дугаар сарын 09-ний өдөр ирүүлсэн “Мэдээлэл ирүүлэх тухай” хариу албан бичигтээ “Хүний эрхийн үндэсний комисс 2018 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 443 гомдол хүлээн авсан ба үүнээс үзэл бодлоо илэрхийлэх эрхийн хүрээнд хэвлэн нийтлэх эрх зөрчигдсөн тухай асуудлаар 2, жагсаал цуглаан хийх эрх зөрчигдсөн тухай асуудлаар 4, мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрх зөрчигдсөн тухай асуудлаар 3 гомдол байна. Харин иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтны эсрэг халдсан, заналхийлсэн, халдахаар оролдсон буюу улс төрийн сэдэлтээр сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтны үйл ажиллагаанд хөндлөнгөөс зүй бусаар нөлөөлсөнтэй холбоотой гомдлыг Комисст ирүүлээгүй байна” гэжээ.
- Улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлтэй хүний эрх болон хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 241 төрийн бус байгууллага байна. Үүнээс 2018 оноос хойш бүртгүүлсэн төрийн бус байгууллага 20 байна. Эндээс харахад, Монгол Улсын 100 мянган хүн тутамд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хөхиүлэн дэмждэг, хамгаалахтай холбоотой үйл ажиллагаа идэвхтэй явуулдаг болон бүртгэлтэй төрийн бус байгууллага дунжаар 7 байна. Мөн нэрэндээ хэвлэл мэдээлэл, сэтгүүлч, мэдээлэл гэх үг хэрэглэсэн төрийн бус байгууллага 32 байна.
- Эрх зүйн зохицуулалтаас гадна өөрийн зохицуулалт Монгол Улсад нэгэн адил үйлчилж байна. Тодруулбал, Хэвлэл Мэдээллийн Зөвлөлийн Ёс зүйн хороодын нэгдсэн хуралдаанаар 2015.04.14-ний өдөр “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”-ыг батлан мөрдүүлж байна.
- Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн хувьд нийтлэл, нэвтрүүлгийнхээ бодит байдалд нийцэж байгаа буюу үнэн зөвийг нотлох үүрэгтэй байна. Гэхдээ энэ нь тэрхүү нотлох баримт буюу эх сурвалжийг нийтлэл, нэвтрүүлэгт заавал дурдах үүрэг хүлээлгээгүй байна.

#### **4.1. ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАТАЛГАА**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хүний эрх, эрх чөлөө бүлгийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ хэмээн заасан. Үүнд:

16.16. Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй.

16.17. Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй.

Монгол Улс НҮБ-д 1961 онд гишүүнээр элсэн орсон бөгөөд гишүүн орны хувьд Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хүлээн зөвшөөрдөг. Түүнчлэн 1974 онд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактыг соёрхон баталж, 2012 онд Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагад гишүүнээр элссэн. Тиймээс олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах үүрэгтэй. Энэ үүргийг Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасан. Эдгээр олон улсын гэрээ конвенци 2004 оны “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн тусгай дугаарт монгол хэлнээ албан ёсоор хэвлэгдсэн.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйл болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлд “Хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй. Хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр, эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана” гэжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.17 дахь хэсэгт “Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” хэмээн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хязгаарлалт тавьж болох зорилго, үндэслэлийг заасан. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.4.4 хэсэгт “Хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй” гэж заасан. Итгэл үнэмшилтэй байвч түүнийгээ илэрхийлэх арга хэрэгсэлгүй бол энэ эрх хэрэгжих боломжгүй юм.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зарим хязгаарлалтыг Үндсэн хуулийн үзэл баримтлал болон олон улсын гэрээ конвенцийг удирдлага болгож, Гурван талт шалгуур /Three part test/-ыг бүрэн хангасан үед л зөвхөн хүлээн зөвшөөрөх ёстой. Үүнд:

**Нэгдүгээрт.** Гагцхүү хуулиар тогтоох

**Хоёрдугаарт.** Хязгаарлалт нь хууль ёсны зорилготой байх

**Гуравдугаарт.** Зайлшгүй буюу гарцаагүй байх, хэмжээндээ байх

Үүнээс өөрөөр хязгаарлалт хийхийг хүлээн зөвшөөрөх ёсгүй ч, илүүц, хүний язгуур эрхийг зөрчсөн хязгаарлалт хууль тогтоомжид тусгагдах, эсвэл практикт хэрэглэсээр байна. 2011 оны 7 дугаар сарын 11-29-ний өдрүүдэд Женев хотноо болсон НҮБ-ын Хүний эрхийн хорооны 102 дугаар чуулганаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлд 34 тоот Ерөнхий тайлбарыг Монгол Улс албан ёсоор орчуулж, практикт хэрэглэж хэвших, таниулах шаардлагатай байна.

## **4.2. ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ БА СЭТГҮҮЛ ЗҮЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

1998 онд баталсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 2, 3, 4 дүгээр зүйлд хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргах болон төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байх, төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тавихыг тус тус хориглосон нь хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулсан суурь зохицуулалт болдог.

Улсын Дээд Шүүх (УДШ)-ийн тайлбарт “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл” гэдгийг “Зар сурталчилгааны тухай” хуулийн 3 дугаар бүлэгт 3.1.5 дахь хэсэгт “Мэдээлэх хэрэгсэл” гэж телевиз, радио, холбооны шугам сүлжээ, компьютерийн сүлжээ, тусгай программ, хэвлэл болон бусад арга хэрэгсэл” гэсэн утгаар ойлгоно хэмээн тогтоосон.

УИХ-аас 2005 оны 1 дүгээр сарын 27-нд “Олон нийтийн радио, телевизийн тухай” хууль баталснаар үндэсний хэмжээнд олон нийтэд үйлчлэх, түүний хяналт санхүүжилтэд байх статус бүхий телевиз, радиогийн эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

Түүнээс хойш хэвлэл мэдээллийн салбарт шаардлагатай байгаа өргөн нэвтрүүлгийн ерөнхий хууль, сэтгүүлчийн нууц эх сурвалжийг хамгаалах, мэдээлэгчийг хамгаалах, салбар дахь шударга өрсөлдөөн, өмчлөлийн ил тод байдлыг хангах тухай эрх зүйн зохицуулалт хийгдээгүй.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэд хэдэн төсөл боловсруулагдсан ч, УИХ-аар хэлэлцүүлж батлуулаагүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.3.8-т “Хэвлэлийн эрх чөлөөг хангах эрх зүйн орчинг сайжруулж, иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, мэдээлэл хайх, хүлээн авах эрхийн баталгааг хангана” гэсэн чиглэлийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/233 тоот тушаалаар Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг шинэчлэн найруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд <sup>1</sup> “Эх орон, үндэс угсаа, ололт дэвшлээрээ бахархах, үндэсний ашиг сонирхол, ёс зүй, хууль, төрт ёсны үзлийг дээдлэх үнэт зүйл бүхий нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх бодлогыг төр, иргэн, хэвлэл мэдээллийн салбар хамтран хэрэгжүүлнэ” (3.3.3.2) гэж заажээ. Түүнчлэн “хэвлэл мэдээллийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлж, хариуцлагатай, мэргэшсэн сэтгүүл зүй, сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг төлөвшүүлж, нийгмийн тогтвортой байдлыг хангана” (3.3.4.3) гэж заасан байдаг.

## **4.3. МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ БА ХЯЗГААРЛАЛТ**

Монгол Улсын Үндсэн хуулийн 16.17 дугаар зүйлд мэдээлэл “хайх, хүлээн авах” эрхийг хамгаалдаг бөгөөд мэдээлэл “түгээх” эрхийн тухай үгчлэн оруулаагүй хэдий ч өмнө дурдсан олон улсын гэрээ конвенцийн дагуу “хил хязгаар үл харгалзан” <sup>2</sup> мэдээлэл “хайх, хүлээн авах болон түгээх” эрх баталгаажсан гэж үздэг.

<sup>1</sup>[“Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2010 оны №36](#)

<sup>2</sup>[ИБУТЭТОУП-ын 19-р зүйл \(2\)](#)

2005 онд батлагдсан Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 34.1 зүйлд “Олон нийтийн радио, телевизийн ажилтан төр, байгууллага болон хувь хүний нууцтай холбоотойгоос бусад мэдээллийг олж авах, нийтийн хүртээл болгох эрхтэй” гэж МҮОНРТ-ийн сэтгүүлчдийн эрхийг баталгаажуулсан. Харин 2011 онд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай (МИТБМАЭ) хууль батлагдсанаар мэдээлэл олж авах эрхээ эдлэх боломж, нөхцөл хэвлэл мэдээлэл, сэтгүүлчид төдийгүй иргэдэд бүрдсэн билээ.

Энэ хуулийн 6 дугаар зүйлд үйл ажиллагаа, төсөв, санхүү, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны мэдээллийг нээлттэй байлгах үүргийг төрийн байгууллагуудад ногдуулсан. Аливаа иргэн, хуулийн этгээд төрийн байгууллагаас хүссэн хэлбэрээрээ мэдээлэл авах хүсэлт гаргах эрхтэй бөгөөд төрийн албан хаагчид хүсэлтийн хариуг дээд тал нь ажлын 7 хоногийн дотор, зайлшгүй тохиолдолд ажлын 14 хоногт өгөх үүрэгтэй. Хариуг нь шууд өгөх боломжтой хүсэлтийг тухай бүр шийдвэрлэж хариу өгнө. Түүнчлэн энэ хуулийн хэрэгжилтийг шалгах зорилгоор тэмдэглэл хөтлөх /23-р зүйл/, энэхүү тэмдэглэл нь үр дүнгийн гэрээг үнэлэх шалгуур үзүүлэлт болгох /24-р зүйл/-оор заасан нь хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих зохицуулалт бий.

Мөн хуулийн 18 дугаар зүйлд заасан өгөхийг хориглосон мэдээллийн төрөл нь хэт ерөнхий, өргөн хүрээг хамарч байна. Үүнд: **(1)** тухайн мэдээллийг нийтэд ил болгосноор Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, нийтийн эрх ашигт хохирол учруулах бодитой үндэслэл байгаа, **(2)** тухайн мэдээлэл нь Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, өрсөлдөөний болон мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хянан шалгагдаж байгаа асуудалтай холбоотой, **(3)** хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны явцад төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах шаардлагатай зэрэг тохиолдол орно. Түүнчлэн уг хууль нь оюуны өмч, хувь хүний нууц болон байгууллагын нууцыг хамгаалдаг. Уг хуулийн 17 дугаар зүйлд эрх нь зөрчигдсөн иргэн, хуулийн этгээд дээд албан тушаалтан, дээд шатны байгууллага болон Хүний Эрхийн Үндэсний Комисс, Захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргаж шийдвэрлүүлнэ.

Уг хуулийн дагуу Засгийн газраас 2013 оны хоёрдугаар сард “Мэдээлэл өгөх үйлчилгээний хөлс төлөх, түүнээс хөнгөлөх, чөлөөлөх журам”, 12 дугаар сард “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам”-ыг тус тус баталсан.

МИТБМАЭ-ийн тухай хуулийн 9 дүгээр зүйл “Төсөв, санхүүгийн ил тод байдал”, 10 дугаар зүйл “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал” заалтуудыг хүчингүй болгож, Шилэн дансны тухай хуулиар зохицуулж байна. Шилэн дансны хуулиар зохицуулахгүй бусад төсөв, худалдан авах ажиллагаатай холбоотой зохицуулалт нь хүчин төгөлдөр үйлчлэх юм.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар нийтийн албан тушаалтнууд ашиг сонирхлын мэдүүлгээ, Авлигын эсрэг хуулиар өөрийн болон гэр бүлийнхээ хөрөнгө, орлого, зээлийг мэдүүлэх үүрэг хүлээсэн тул энэ төрлийн мэдээлэл нээлттэй болж байна.

2017 онд батлагдсан Зөвлөлдөх санал асуулгын тухай хууль, Ирээдүйн өв сангийн тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, Хөгжлийн банкны тухай хууль, Барилгын тухай хууль, Эрүүл ахуйн тухай хуульд МИТБМАЭ-ийн тухай хуульд нийцүүлэн олон нийтэд ил тод, нээлттэй, олон нийтэд мэдээлэх зарчмыг зүйлчилсэн байна. Мөн ил тод, нээлттэй байх үүргийн хүрээнд хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг заавал байлцуулах, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр заавал түгээх тухай хуулийн заалтууд шинээр батлагджээ. Тухайлбал, 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр батлагдсан Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 19 дүгээр зүйлийн нэг

дэх хэсэгт “Хэсэгт санал тоолох ажиллагааг санал асуулга явуулах өдрийн 22.00 цагт эхэлж, ажиглагч, хэвлэл мэдээллийн болон иргэний төлөөлөгчийг байлцуулан ил тод, нээлттэй явуулна” гэжээ. Мөн 2015 оны 7 дугаар сарын 8-ны өдөр батлагдсан Нийтийн сонсголын тухай хуулийн “Сонсголын нийтлэг журам” хэмээх 18 дугаар зүйлийн нэг дэх хэсгээр “Нээлттэй сонсголд хэвлэл мэдээллийн төлөөллийг заавал оролцуулах” үүрэг хүлээлгэжээ.

2016 оны 12 дугаар сарын нэгний өдөр УИХ-аас “Төрийн болон албаны нууцын тухай хууль”-ийг УИХ-аар баталсан ба үүнтэй холбогдуулан Төрийннууцынжагсаалтбатлахтухай хууль, Байгууллагыннууцын тухай хуулийг 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болгож, төрийн байгууллагын албаны нууцтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулдаг болжээ. Шинэ хуулиар онц чухал мэдээлэл нууцлах хугацааг 60 жилээс 30 жил болж, багассан байна.

Гэвч шинэ хуульд орсон зарим зохицуулалт анхаарал татаж байна. Тухайлбал, уг хуулийн “Хуулийн нэр томъёоны тодорхойлолт” хэмээх 5 дугаар зүйлийн 5.1.2-т “албаны нууц гэж задруулах, үрэгдүүлэх, тохиолдолд салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээлэл” гэж тодорхойлжээ. Энэ нь олон нийтийн эрх ашгаас дээгүүр, МИТБМАЭ-ийн тухай хуулийн үзэл баримтлал, зарчимтай зөрчилдсөн гэж болохоор байна.

Мөн шинэ хуулиар төрийн нууцад хамаарах мэдээллийн хүрээг “төрийн бодлого, эдийн засаг, шинжлэх ухаан, техник технологи, батлан хамгаалах, тагнуул, сөрөх тагнуул, хууль сахиулах ажил, мэдээллийн аюулгүй байдлын болон бусад хүрээнд” хэмээн тогтоосон нь хэт өргөн хэвээр байна. Түүнчлэн, хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5-д мэдээллийг төрийн болон албаны нууцад хамааруулах, нууцыг шилжүүлэх, ил болгох, нууцын зэрэглэл тогтоох, өөрчлөх, нууцын хугацааг сунгах асуудал нь Засгийн газрын бүрэн эрхэд хамаарахаар хуульчилжээ. Энэ нь Монгол Улсын Үндсэн Хуулийн төр, байгууллагын нууцыг хуулиар тогтоон хамгаалах тухай заалттай нийцэж байгаа нь эргэлзээтэй.

2017 оны 6 дугаар сард Засгийн газраас МИТБМАЭ-ийн тухай хуулийг үндэслэн “Төрийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журам”-ыг баталсан нь иргэдэд төрийн мэдээллийг шуурхай, чирэгдэлгүйгээр хүргэхэд тодорхой ахиц авчирна гэж найдаж байна. Тодруулбал, тус журмын хүрээнд Тагнуулын ерөнхий газар төрийн цахим мэдээлэл солилцооны системээр солилцох төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг гаргахаар заасан байна. Мөн Үндэсний дата төв нь иргэдэд үйлчилгээ үзүүлэх төрийн нэгдсэн үйлчилгээний порталын хөгжүүлж иргэн, байгууллагад үйлчлэх цахим үйлчилгээний нэр төрөл, тодорхойлолтыг нийтэд мэдээлэхээр тусгажээ.

#### **4.4. СОНГУУЛЬ БА ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ**

2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр тусдаа байсан хэд хэдэн сонгуулийн хуулийг нэгтгэн Сонгуулийн тухай хуулийг шинээр батласан билээ. Энэ хуулийн “Сонгуулийн сурталчилгаа” гэсэн 9 дүгээр бүлэгт бүхэлдээ нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр, түүний агуулгын хяналт, хэвлэмэл болон радио телевиз, цахим орчноор мэдээлэл түгээхтэй холбоотой зохицуулалтыг оруулсан.

Гэвч Сонгуулийн тухай хууль нь буцаад Ерөнхийлөгчийн, УИХ-ын, Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн хуулиар тус бүрдээ зохицуулагдахаар болж

Сонгуулийн Ерөнхий хорооноос холбогдох саналуудыг тусган Төрийн байгуулалтын байнгын хороо руу шилжүүлээд байна.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3.1-т “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ” гэж заасан байдаг бол тус хуулийн төсөлд сэтгүүлч дангаар хариуцлага хүлээдэг байхаар тусгасан байгаа нь дээрх хуулийн заалттай зөрчилдөж байна. Мөн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд төрийн ямарваа нэгэн хэлбэрийн цензур тавихыг хуулиар хориглосоор аталсонгуулийн үеийн хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд төрийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохоор зохицуулсан нь олон улсын хэм хэмжээ болон дотоодын хууль тогтоомжуудтай зөрчилдөж байна.

#### **4.5. НЭР ТӨР ГУТААХТАЙ ХОЛБООТОЙ ЗОХИЦУУЛАЛТ**

Одоогоор Монгол Улсад иргэний нэр төрийг Иргэний хууль болон Зөрчлийн тухай хуулиар хамгаалж байна. 2017 оны 7 дугаар сарын 1-ээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар “Нэр төр гутаах” гэсэн бие даасан зүйлийг хассан нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалахад гарсан ахиц юм. Гэсэн хэдий ч Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 11.2 дугаар заалтад “...нэр төр, алдар хүндийг нь гутаан доромжилсон... улмаас сэтгэл санааны гэнэтийн цочролд хоромхон зуур автаж сэтгэцийн хэвийн байдал алдагдсаны улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан бол зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” хэмээн заасан нь нэр нөлөө бүхий хүмүүс сэтгүүлчдийн эсрэг цензур болгон ашиглаж болзошгүй гэсэн болгоомжлол төрүүлж байна.

УИХ-аас 2017 оны тавдугаар сарын 11-ний өдөр Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль баталж, 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон билээ. Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 6.21 дүгээр зүйлээр хүний нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд, дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан хувь хүн, хуулийн этгээдийг торгох шийтгэл ногдуулахаар хуульчилсан.

Зөрчлийн тухай хууль үйлчилж эхэлснээс хойш 2018 оны 10 дугаар сарын байдлаар гүтгэх зөрчлийн талаарх 374 гомдлыг хүлээн авч, 57 иргэн болон хоёр хуулийн этгээдийг гүтгэх зөрчил үйлдсэн гэж цагдаагийн байгууллагаас нийт 118,000,000 төгрөгөөр торгожээ. Түүнчлэн 6 иргэн шүүхэд гомдол гаргаснаас 3 хүний гомдлыг хангаж, шийтгэлээс чөлөөлсөн байна. Энэ нь Зөрчлийн тухай хууль нь шүүмжлэл болон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлах зорилгоор ашиглагдах эрсдэлтэй байгааг харуулж байна.

Иргэний хуулийн 497 дугаар зүйлд зааснаар “Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй”. Мөн хуулийн 511 дүгээр зүйлд зааснаар “Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан, эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ”.



Нэр төр сэргээлгэх тухай Иргэний хуулийн зохицуулалтын нэг асуудалтай тал нь нийтийн албанд хамаарах байгууллагад нэр төр сэргээх боломж олгодогт байна. Өөр нэг тулгамдсан асуудал нь, Иргэний хуулийн дагуу иргэн, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан бол түүнийхээ “бодитой”, “үнэн зөв” гэдгийг нотлохыг мэдээ тараагчид ногдуулсан.

#### **4.6. АГУУЛГЫН ХЯЗГААРЛАЛТ**

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй Хүүхдийн эрхийг хамгаалах тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай, Садар самуун явалтай тэмцэх тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай, Хүн худалдаалахтай тэмцэх, Зохиогчийн эрх ба түүнд хамаарах эрхийн тухай зэрэг олон хуульд агуулгын хязгаарлалтыг тогтоосон. Эдгээр хязгаарлалт нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хийгдсэнийг бид хүлээн зөвшөөрч байгаа боловч нэр томъёоны хувьд ерөнхий, тодорхойлолт байхгүй, хамрах хүрээг тогтоогоогүй нь хэтрүүлэн ашиглах нөхцөл үүсгэж болзошгүй бөгөөд шүүмжлэл өрнүүлсэн сэтгүүлчдэд халгаатай заалт болж байна.

2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр батлагдсан Хүүхэд хамгааллын тухай хуулийн “Хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал” хэмээх 8 дугаар зүйлээр хүүхдийг түүний хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хамгаалах, хүүхэд хамгаалах зөвлөмж, зааварчилгааг олон нийтэд тогтмол мэдээлж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах зохицуулалт орсон нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын Пактын 19 дүгээр зүйлийн нийгмийн дэг журмыг хангах үүднээс хуулиар тогтоосон, зайлшгүй хязгаарлалтын тухай заалтад нийцэж байна.

ХХЗХ нь 2011 онд баталж, 2015 онд нэмэлт өөрчлөлт оруулсан “Телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”, “Тоон контентын үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”-аар тогтоосон хэм хэмжээ нь шинжийн хувьд авч үзвэл гадагш чиглэсэн, заавал дагаж мөрдөх, захиргааны байгууллагаас гаргасан тул Захиргааны хэм хэмжээний актууд юм. Гэсэн хэдий ч эдгээр хэм хэмжээнд Хууль зүйн яамны нөлөөллийн үнэлгээ хийгдээгүй, улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй байна. Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор баталсан Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журамд зааснаар “улсын бүртгэлд бүртгэгдээгүй шийдвэрийг хүчин төгөлдөр бус гэж үзэж тухайн шийдвэрийг биелүүлээгүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хариуцлага хүлээлгэхгүй” тухай заасан. 2019 оны гуравдугаар сарын байдлаар Харилцаа холбооны зохицуулах хорооноос гаргасан ХЗДХЯ-нд бүртгэлтэй есөн захиргааны хэм хэмжээний акт байна.

Гэсэн хэдий ч нөхцөл шаардлагуудыг хүчин төгөлдөр мөрдөхийг шаардан, радио телевиз, цахим хуудасны агуулгад хяналт тавьж, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, хандалтыг хаах зэрэгт үндэслэл болгон хэрэглэсээр байна.

Одоогоор сонин хэвлэлийн агуулгын зохицуулалт байхгүй. Радио, телевизийн хувьд “нийтийн эрх ашгийг” дээдлэх (5.1) үүрэг ногдуулж, долоо хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 50-иас доошгүй хувь нь Монгол Улсад бүтээгдсэн, эсхүл Монгол Улсын иргэн, Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн бүтээсэн нэвтрүүлэг” (5.4) байхаар заажээ.



Сүүлийн үед УИХ-аас батлагдан гарч буй хууль, хэлэлцүүлгийн шатанд яваа хуулийн төслүүдэд хэвлэл мэдээллийн хэрэгсэлд үүрэг ногдуулах, илүүц хязгаарлалт, хориг тавих, үүгээр дамжуулан төрийн байгууллагууд цагдан хяналт тогтоох эрсдэл нэмэгдэх хандлагатай байна.

Тухайлбал, Соёлын тухай хуульд 2015 оны 2 дугаар сарын 12-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан. Энэ өөрчлөлтөөр “Соёлын хүрээнд төрийн болон бусад байгууллага, иргэнээс явуулах үйл ажиллагаанд тавих хязгаарлалт” гэсэн (19) зүйлд нэмэлт оруулсан. Энэ зохицуулалтын гол агуулга нь үндэсний нэвтрүүлгийг дэмжих төрийн бодлоготой уялдаж байгаа ч, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд дарамт учруулж болзошгүй үүрэг ногдуулалт юм.

## **4.7. БУСАД ЗОХИЦУУЛАЛТ**

### ***Хэвлэл мэдээллийн өмчлөл ба төвлөрөл***

Хэвлэл мэдээллийн байгууллагуудын дийлэнх буюу 78 хувийг хувийн компани, хувь хүн эзэмшиж байна. Энэ нь салбар тус бүрт, ялангуяа телевизэд илүүтэй байгаа бөгөөд ойролцоогоор арван телевиз тутмын ес нь хувийн эзэмшилд байна. Үүнээс төрийн байгууллагад хамаарах 15 сонин, 12 сэтгүүл, 12 радио, 3 телевиз, 2 мэдээллийн сайт байна<sup>3</sup>. Монгол Улсад бүх хэвлэл мэдээллийн хэрэгсэл бүртгэлтэй байх ёстой бөгөөд байгуулагдсанаас хойш 10 хоногийн дотор бүртгүүлэх өргөдлөө гаргах үүрэгтэй. Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийг үндэслэн улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх нь зүйн хэрэг. Гэсэн хэдий ч практикт бүртгүүлэх бичиг баримтын шаардлагад төрийн бус байгууллагын дүрэмд тавих шаардлагыг тавьж байгаа нь ашгийн ба ашгийн бус хуулийн этгээдийн үйл ажиллагааны зарчмыг хольж байна. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.16.1 дүгээр зүйлд заасны дагуу радио, телевизийн байгууллага нь зөвхөн тусгай зөвшөөрөл авсны дараа бүртгүүлэх ёстой. Харин тусгай зөвшөөрөл авахын тулд тухайн засаг захиргааны Засаг даргын саналыг авах шаардлагатай.

Монгол Улсад хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөл олон төрөлтэй хэдий ч хуульд өмчлөлийн олон талт байдлыг тусгаагүй. Хүйн хэвлэл мэдээллийн хэрэгслийг бодлого, зохицуулалтын аль ч түвшинд хүлээн зөвшөөрөөгүй байна.

2010 онд батлагдсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д “Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил, харьяалал нь ил тод байх” заалт анх удаа тусгагдсан юм.

УИХ-ын 2012 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшигч болон орлогын тухай мэдээллийг ил болгоно; хэвлэл мэдээллийн байгууллагын хараат бус байдлыг бэхжүүлнэ; хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулна” хэмээн заажээ.

ХХЗХ-ны 2015 оны 15 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж баталсан “Телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”-ын “Эзэмшлийн ил тод байдал” гэсэн 5 дугаар бүлэгт “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өргөн нэвтрүүлгийн хараат бус байдлыг хангах, нээлттэй, ёс зүйтэй байдлыг эрхэмлэх зорилгоор тусгай зөвшөөрлийг олон нийтэд ил тод байлгана. Хөрөнгө оруулагч, тусгай зөвшөөрөл эзэмшигч, удирдлагын эзэмшлийн хувь хэмжээ, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, дэлгэрэнгүй хаяг, харилцах

<sup>3</sup>Монголын хэвлэл мэдээлэл-Өнөөдөр, 5-р тал

утас, хуулийн этгээдийн удирдлага зохион байгуулалтын бүтэц, удирдах ажилтнуудын иргэншлийн тухай мэдээллийг жил бүрийн I улиралд багтаан Зохицуулах хороонд албан бичгээр мэдэгдэх"-ээр тусгасан.

Хэвлэл мэдээллийн эзэмшил, харьяалал нь компани, хувь хүмүүсийн өөр өөр нэр дээр бүртгэгдсэн тул жинхэнэ эзэмшигчид нь ил тод бус, борлуулалтын мэдээлэл болон хэрэглэгчдийн зах зээлд эзлэх хувийг нууцалдаг учир төвлөрлийг бодитоор тогтоох боломж хомс байна.

2013 онд батлагдсан Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь хэсэгт хэвлэл, мэдээлэл, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг гадаадын төрийн өмчит хуулийн этгээд эзэмших тохиолдолд зөвшөөрөл авахаар зохицуулсан.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд төрийн өмчлөлийг хориглосон ч сүүлийн жилүүдэд орон нутгийн засаг захиргаа үйл ажиллагаа, бодлогоо сурталчлах телевиз, сонин олноор байгуулж, хууль зөрчиж байна. Хэвлэл мэдээллийн өмчлөл нууц байх, хэвлэл мэдээлэл нэг гарт төвлөрөх нь редакцийн цензурыг өөгшүүлж, ингэснээр хэвлэлийн эрх чөлөөг боогдуулан, олон ургальч үзлийг сааруулж, сэтгүүл зүйн мэдээллийн чанарт сөргөөр нөлөөлж байна. Хэвлэл мэдээллийн зах зээл бүрэн төлөвшөөгүй, хэвлэл мэдээллийн байгууллагууд зар сурталчилгааны орлогын төлөө шударга өрсөлдөхөөсөө илүү төрийн байгууллага, улс төр, бизнесийн байгууллагатай гэрээ хийн, үйл ажиллагаа явуулж байна.

### **Өргөн нэвтрүүлэг**

Монголд өргөн нэвтрүүлгийн бие даасан хууль батлагдаагүй хэвээр байна. Өргөн нэвтрүүлгийн салбарын үйл ажиллагаатай холбогдох харилцааг Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай зэрэг хуулиудаар зохицуулж байгаа бөгөөд өргөн нэвтрүүлгийн зах зээл өдрөөс өдөрт өргөжин хөгжиж, өргөн нэвтрүүлгийг зөвхөн телевиз, радио ашиглан хүлээн авахаас гадна гар утас, компьютер болон автомашины хүлээн авагчаар хүлээн авч үзэх боломжтой болж, ашиглах цар хүрээ, тавигдах шаардлага өөрчлөгдөж байна. Улсын Их Хурлаас 2005 онд Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийг баталсан боловч уг хууль нь зөвхөн Үндэсний олон нийтийн радио, телевизийг үүсгэн байгуулах, үйл ажиллагааны зарчим, эрх зүйн үндсийг тогтоож, хөтөлбөрийн бодлогын зарчмыг тодорхойлоход чиглэгдсэн болно. Гэтэл өнөөгийн байдлаар улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах эрх бүхий 84 телевиз, радио нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмших эрх бүхий телевиз Улаанбаатар хотод 29, орон нутагт 66, кабелийн сувгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч Улаанбаатар хотод 77, орон нутагт 8, олон сувгийг дамжуулах үйлчилгээ эрхлэгч буюу кабелийн телевизийн үйлчилгээ эрхлэгч Улаанбаатар хотод 16, хиймэл дагуулаар олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч 1, орон нутагт 50 байгаа бөгөөд эдгээр тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааг зохицуулах хууль, эрх зүйн орчин дутагдалтай байна

Олон улсын жишгээр хэвлэл мэдээллийн салбарыг зохицуулах байгууллага нь Засгийн газраас хараат бус байж, давтамжийн зурвас хуваарилалтыг зохицуулах ёстой. "Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлд үндэслэн зохицуулах байгууллага болох Харилцаа холбооны зохицуулах хороог 1995 онд байгуулсан. Радио долгионы тухай хуулийн 4 дүгээр зүйлд "Монгол Улсын нутаг дэвсгэр дэх үүсгэгчээс үүссэн болон үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтэд багтаж байгаа радио долгион нь Монгол Улсын төрийн өмч" мөн. ХХЗХ нь Засгийн газрын хэрэгжүүлэгч байгууллага мөн бөгөөд Монгол Улсын Ерөнхий сайдаас шууд томилдгоос үзвэл хараат бус

байгууллага биш гэдгийг илтгэнэ. Энэ нөхцөл байдал нь радио долгионы давтамжийн хуваарилалт, зохицуулалт хараат бус явагдах боломжийг хааж байна.

Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал бэлэн болсон бөгөөд 2019 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар тус хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийлээ. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны хоёрдугаар сарын 20-ны өдрийн 47 дугаар тогтоолоор Төрөөс мэдээлэл, харилцаа, холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого батлагдсан бөгөөд уг бодлогын баримт бичгийн 3.2.1-д “Мэдээлэл харилцаа холбооны салбарын эрх зүйн актыг боловсронгуй болгож, Монгол Улсын хууль болон олон улсын гэрээнд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, мөрдүүлнэ” гэжээ. Гэсэн хэдий ч, Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ)-ны удирдлага, гишүүдийн томилгоог хараат бус болгох тухай дурдаагүй байна. Цаашид тус бодлогоо хэрэгжүүлэхэд анхаарч ажиллана гэдэгт бид найдаж байна.

### **Интернэт**

Монгол Улсад хэрэглэгчид дотоод, гадаадын аль ч сайтад нэвтэрч, нийгмийн сүлжээнд нэгдэж, харилцахыг төрөөс хязгаарласан зохицуулалт байхгүй. “Тоон контентын үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”-д “контент” гэдгийг “харилцаа, холбооны сүлжээгээр дамжиж байгаа тэмдэгт, дохио, текст, зураг, дуу, авиа, дүрс, бичлэг болон бүх төрлийн мэдээ мэдээллийг тоон хэлбэрт хувиргасан бүтээгдэхүүнийг хэлнэ” гэж тодорхойлжээ. Харин цахим шуудан, балк болон спам захидал, хувь хүмүүсийн хоорондын харилцаа (телефон яриа, факс, айпи телефон яриа гэх мэт) контентэд хамаарахгүй. Монгол Улсын Засгийн газрын баталсан “Цахим хуудас дахь сэтгэгдлийн нэгдсэн систем”-ийн тухай 2013 оны 01 тоот тогтоолоор мэдээллийн сайтуудад тавигдах шаардлага, домэйн хаяг олгох ажлыг зохицуулах журам гаргахыг ХХЗХ-д үүрэг болгов. Үндэсний Дата төвөөс сэтгэгдлийн нэгдсэн системийн техникийн ажиллагааг хангаж, Улсын бүртгэлийн ерөнхий газар сайтууд дээр сэтгэгдэл бичиж буй хэрэглэгчдийн тухай мэдээллийг бүртгэж байх үүрэг хүлээсэн. Тэд хэрэглэгчдийн тухай мэдээлэл бүрдүүлэхдээ Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн сан болон үүрэн телефон хэрэглэгчдийн мэдээллийг ашиглахаар зохицуулсан. Цахим орчинд нэрээ нууцлах эрхийг хязгаарласан энэ тогтоол хүчин төгөлдөр үйлчилсээр байна.

НҮБ-ын Үзэл бодлын эрх чөлөөний Тусгай илтгэгч, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (OSCE)-ын Хэвлэлийн эрх чөлөөний төлөөлөгч болон Америкийн муж улсуудын байгууллага (OAS)-ын Үзэл бодлын эрх чөлөөний Тусгай илтгэгч нарын 2005 оны 12 дугаар сарын 21-ний өдөр баталсан Хамтарсан Тунхаглалд “Интернэтийн үйлчилгээ, цахим хуудас, блог эрхлэх, онлайннар мэдээлэл түгээх, интернэтийн өргөн нэвтрүүлэг дамжуулахад төрийн аливаа байгууллагад бүртгүүлэх, тэднээс зөвшөөрөл авахыг хэнээс ч шаардах ёсгүй. Энэ нь цэвэр техникийн зориулалттай домэйн нэр эзэмшлийн бүртгэл, мөн арилжааны үйл ажиллагааны бүхий л төрөлд ялгаварлалгүйгээр хэрэглэгдэх хэрэглээний ерөнхий журамд хамаарахгүй” хэмээн заасан байдаг.

Гэвч ХХЗХ нь хязгаарлалтыг дүрэм журмаар тогтоосоор байна. “Тоон контентын үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”-ын 3.4 дэх хэсэгт зааснаар Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй мэдээ мэдээллийн вэбсайтын үйлчилгээ эрхлэгч нь Зохицуулах хороонд бүртгүүлэх үүрэг хүлээж байна.

Энэ журмаар вэбсайтын үйлчилгээ эрхлэгчид нь хэрэглэгч контент үүсгэх боломжтой, хэрэглэгчийн сэтгэгдэл үлдээх хэсэгтэй бол дараах зохицуулалтыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно. Үүнд:

- Зохицуулах хорооноос ажиллуулж байгаа үгийн шүүлтүүр программыг заавал ашиглах;
- Хэрэглэгчийн интернэт хаягийг (IP address) бүтнээр нь хэрэглэгчийн үүсгэсэн контентын дээр нийтэд харагдахуйц байрлуулах;
- Хэрэглэгч дурын нэр (username), имэйл хаягаар логин хийх сэтгэгдэл үлдээх боломжийг бүрдүүлэх
- Тухайн сэтгэгдэлтэй холбоотой үүсэх логийг багадаа 6 сар хадгална.

Энэ ерөнхий нөхцөл шаардлагыг биелүүлээгүй вэбсайтын үйлчилгээ эрхлэгчийн Монгол Улсаас хандах хандалтыг хязгаарлана. ХХЗХ нь холбогдох эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хууль, тогтоомж зөрчсөн тухай албан ёсны шийдвэр, дүгнэлтийг үндэслэн вэб сайтын үйлчилгээ эрхлэгчид мэдэгдэнэ. Мэдэгдсэнээс хойш 24 хүртэлх цагийн дотор, шаардлагатай гэж үзвэл нэн даруй уг зөрчлийг арилгах арга хэмжээ авч хариуг мэдэгдэнэ /9.2.1/. Эрх бүхий байгууллагаас Монгол Улсад хандах хандалтыг хязгаарлах тухай ирүүлсэн албан ёсны мэдэгдэл, албан бичигт үндэслэн тухайн вэбсайтын үйлчилгээ эрхлэгчид мэдэгдэл хүргүүлэхгүйгээр вэбсайтын хандалтыг нэн даруй хязгаарлаж болно.

Зохицуулах хороо зөрчлөөс хамааруулан тусгай зөвшөөрлийн гэрээнд заасан эдийн засгийн хариуцлага хүлээлгэх эсвэл хугацаатай үүрэг даалгавар, шаардлага өгөх; захиргааны хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авахуулахаар холбогдох хяналтын байгууллагад мэдэгдэх; тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай сануулах; хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авах эрхтэй байхаар журамласан байна.

### **Өөрийн зохицуулалт**

Урт хугацааны яриа хэлэлцүүлгийн үр дүнд анхны өөрийн зохицуулалтын байгууллага болох Монголын Хэвлэл мэдээллийн зөвлөл 2015 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр албан ёсоор байгуулагдсан. Монголын Хэвлэл мэдээллийн зөвлөлийг 15 хүний бүрэлдэхүүнтэй Удирдах зөвлөл удирдах бөгөөд телевиз, радиогийн ёс зүйн хороо (15 хүн), сонин, сэтгүүл, сайтын ёс зүйн хороо (15 хүн), ажлын алба, гүйцэтгэх захиралтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Сүүлийн дөрвөн жилд ХМЗ-ийн үйл ажиллагаа өргөжин тэлж, иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас тус зөвлөлд өргөдөл гомдол гаргах нь нэмэгдэж байна. Тухайлбал, 2015 онд 19 хэвлэл мэдээллийн редакцид хаягласан өргөдөл гомдлыг хүлээж авч шийдвэрлэсэн бол 2018 онд энэ тоо тав дахин нэмэгджээ. ХМЗ байгуулагдсан цагаасаа хойш иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас сэтгүүл зүйн ёс зүйн зарчмыг зөрчсөн гэж үзсэн нийт 227 өргөдөл гомдлыг хүлээн авч, шийдвэрлээд байна.

### **Сэтгүүлчийн нууц эх сурвалж**

Монгол Улсад сэтгүүлчийн нууц эх сурвалжийг хамгаалах хууль одоо болтол байхгүй байна. Зөвхөн Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “олон нийтийн радио, телевизийн ажилтан мэдээллийн эх сурвалжийг нууцлах эрхтэй” гэж заасан.

“Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”-ын 8 дахь “Мэдээллийн нууц эх сурвалжаа чандлан хамгаална” гэсэн заалтаар сэтгүүлчдэд нууц эх сурвалжаа хамгаалах ёс зүйн үүргийг хүлээлгэдэг.

Эдгээрээс гадна нэг олзуурхууштай зүйл нь 2016 онд батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тоот тогтоолоор баталсан явдал юм. Учир нь тус хөтөлбөрийн 4.1.8 дахь хэсэгт хэвлэл мэдээллийн байгууллагын хараат бус байдал, сэтгүүлчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр тодорхой ажлууд хийхээр тусгаад байна. Тухайлбал:

- хэвлэл мэдээллийн байгууллагын мэдээлэл олж авах, түгээх эрхийг баталгаажуулах /4.1.8.1./;
- эрэн сурвалжлах замаар авлига, албан тушаалын гэмт хэргийн талаар мэдээлсэн сэтгүүлчийг аливаа дарамт, шахалтаас хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох, сэтгүүлчийг мэргэжлийн үйл ажиллагааных нь улмаас эрүүгийн хариуцлагад татах явдлыг өөрчилж, аюулгүй байдлыг хангах зохицуулалтыг бий болгох /4.1.8.2./;
- хэвлэл мэдээллийн байгууллагын бие даасан, хараат бус байдал, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлэх /4.1.8.3./ гэж тус тус заасан.

Эдгээрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө батлагдсантай холбоотойгоор сэтгүүлчийн нууц эх сурвалж, шүгэлдэгчийг хамгаалсан эрх зүйн орчин бүрдэнэ гэсэн хүлээлт өндөр байгаа юм.